

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ДАГУУ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ БОЛОН ОЛОН ТАЛТ ОЛОН  
УЛСЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2026 оны 05 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Их Хурлын тогтоолын дагуу хүний эрх, эрх чөлөө болон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах арга хэмжээний төлөвлөгөөний “Хүний эрхийн үндэсний форум-2025” 9 дүгээр зөвлөмжийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамааран хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний нэгдүгээр улирлын хэрэгжилтэд тулгуурлан Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж дүгнэв.

“Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-ний хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах талаар аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ “хэрэгжсэн” буюу 100 хувьтай, зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх, үр нөлөөг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой үр дүнд хүрч 50 хувь буюу “хэрэгжих шатандаа” байгаа нь дундаж үнэлгээгээр 75 хувь үнэлэгдлээ. (Хүснэгт 1.)

(Хүснэгт 1.)

		Бүгд	Үүнээс
			УИХ-ын тогтоол
Гурав. Засаглал			
Эрх зүйн орчин			
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		1	1
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		2	2
Үнэлгээ	Хэрэгжсэн		1
	Хэрэгжих шатандаа	Тодорхой үр дүнд хүрсэн	1
		Удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай	-
	Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас	-
		Хөрөнгө дутагдсанаас	-
	Хугацаа болоогүй		-
	Хэрэгжих боломжгүй		-
Хяналтаас хасуулах санал (хүчингүй болсон эсэх)		-	
Дүн (хувь)		75	75

**Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт (Хүснэгт 2.)**

Д/д	Зүйл, заалт дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Дундаж хувь
Хоёр. Хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах талаар аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ			
1	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариуцан арилгах, үр нөлөөтэй шийдвэрлэх талаар аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах, энэ чиглэлээр бодлогын үүрэг амлалт гаргаж хэрэгжүүлэхийг уриалах	“Хүний эрхийн үндэсний форум-2025” 9 дүгээр зөвлөмж	100
Гурав. Зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх, үр нөлөөг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ			
2	Бизнес ба хүний эрхийн талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, иргэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо барагдуулах талаар мэдлэг, боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, орон нутгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах	“Хүний эрхийн үндэсний форум-2025” 9 дүгээр зөвлөмж	50
Хэсгийн дундаж үнэлгээ			75

**Дүгнэлт, санал**

Тайлант хугацаанд хяналтад авсан “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-ний 2 арга хэмжээний хэрэгжилт 75 хувьтай үнэлэгдлээ.

Дээрх “засаглал”-ын буюу эрх зүйн орчинд хамаарах шийдвэрийг хэрэгжүүлэхэд төсөв санхүүгийн асуудлыг шийдэж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох шийдвэр гарч тодорхой үр дүнд хүрсэн буюу “хэрэгжих шатандаа” байгаа дараах арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх шаардлагатай. Үүнд:

Иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх 3.16: Бизнес ба хүний эрхийн талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, иргэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо барагдуулах талаар мэдлэг, боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, орон нутгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах

Хэрэгжилт: Бизнес ба хүний эрхийн талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, иргэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар мэдлэг олгох, мэдээлэл хүргэх зорилгоор байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан зөвлөмж, мэдээлэл сурталчилгааг тогтмол хүргэн ажиллаж байна. 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар хуурамч визийн зөвшөөрлөөс урьдчилан сэргийлэх, “Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл гаргуулж өгнө, мөн албадан гаргах арга

хэмжээнээс чөлөөлүүлнэ” гэх худал зар, мэдээлэлд автахгүй байхыг сэрэмжлүүлж, 4 удаагийн санамж бэлтгэн олон нийтэд түгээлээ. (50 хувь)

Цаашид дээрх төлөвлөгөөний байгууллагад хамаарах 2 арга хэмжээний хэрэгжилтийн чанарт анхаарч, үр дүнг бууруулахгүй ажиллахыг санал болгож байна.

--oo0oo--